



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/142

Хэрлэн сум

Хэрлэн сумын 1 дүгээр багийн халаалтын зуухны ажлыг дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 1 дүгээр багийн халаалтын зуухны барилгын ажилд оролцогч талуудын уялдаа холбоог хангаж, барилгын ажлын дутуу гүйцэтгэлийг хангуулж, ашиглалтад хүлээлгэн өгөх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн  
дарга:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон сууц, газрын харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн

Орон нутгийн өмчийн газрын дарга


Эрчим хүчний улсын ахлах байцаагч

“Хэнтий Ус” ХХК-ийн гүйцэтгэх захирал

2.Үйл ажиллагааны хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



D:\My Documents\Захирамж-2025

231010106

